

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

| Хуулийн нэр | Хуулийн зорилго | Худалдаатай холбоотой заалтууд |
|---|--|--|
| ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | 1.1.Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. | ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ХЭРЭГЛЭЭ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 6 дугаар зүйл. Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлага 6.1. Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаархи эрүүл мэндийн дүгнэлтийг улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тамхины төрөл тус бүрээр олгоно. 6.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт тавих стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батална. 6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно: 6.7.1. тамхины найрлагад агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заагаагүй; 6.7.2. янжуурыг нэг хайрцагт 20 ширхгээс цөөнөөр, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах; 6.7.7. 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах; 6.7.8. тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах; 6.7.9. тамхи худалдах автомат машин ажиллуулах; 6.7.10. тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах; 6.7.11. хайрцаг, сав, баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, он, сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлгүй; 6.7.12. зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах. 6.7.13. интернэтээр тамхи худалдах; 6.7.14. ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах; 6.8. Тамхи, тамхин бүтээгдэхүүний худалдаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 6.8.1. худалдан авагчийн насыг тодорхойлох зорилгоор иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтаа үзүүлэхийг шаардах; 6.8.2. энэ хуулийн 6.8.1-д заасан бичиг баримт үзүүлэхээс татгалзсан бол түүнд тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх. 6.9. Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг Засгийн газар батална. |

